



МОНГОЛ УЛСЫН  
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 475

Улаанбаатар хот

Хяналтын хуудас шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 16.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын 2024 оны 232 тогтоолоор "Ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалахад мөрдөх техникийн зохицуулалт" батлагдсантай холбогдуулан хяналт шалгалтад хэрэглэх Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах 07.2.1 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөрийн хяналтын хэлтэс (Б.Батзориг) -т үүрэг болгосугай.
3. Хяналтын хуудсыг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын (ахлах) байцаагчид батлагдсан өдрөөс эхлэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд дагаж мөрдсүгэй.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/42 дугаар тушаалын гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.АУБАКИР